



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/290

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 8/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын хэмжээнд нийтийн эзэмшлийн 150 га газрын хог, хаягдлыг цэвэрлэх зардалд зарцуулах 5.0 сая төгрөг /Гаван сая/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2.Тус арга хэмжээнд зарцуулах 5.0 сая төгрөгийг аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 1.1 дэхь заалтын “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бодлого зорилтыг хэргжүүлэх, байгаль орчны хуулийн хэрэгжилтийг хангах” хөтөлбөр, арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Тус арга хэмжээний ажлыг гэрээлэн гүйцэтгүүлж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 08-ны өдрийн
А/290 дүгээр захирамжийн хавсралт



ЖАРГАЛАНТ СУМЫН ХЭМЖЭЭНД НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН
ГАЗРЫН ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

ДД	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Тоо	Нэгж зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/
1	Ажиллах хүчний зардал	Ажиллах өдөр	Өдөр	5	1500	187500
		Хүний тоо	Хүн	100	7000	3500000
	Дүн					3687500
2	Зарцуулах шатахуун	Ай-92	Летр	40	1950	390000
		Түлш		70	2250	787500
	Дүн					1177500
3	Хөдөлмөр хамгаалал, багаж хэрэгсэл	Ажлын бээлий	Ш	210	400	84000
		Шуудай	Ш	200	250	50000
	Дүн					134000
Нийт дүн						5000000